




GOBI

ГОВЬ ХК-ИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ТАЙЛАНТ ХУГАЦАА: 2025.01.01 - 06.30



1.	КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА		3
2.	САНХҮҮГИЙН ҮР ДҮН		6
3.	2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД БИД		10
4.	БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ		18
5.	ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ		37



КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА





ГОВЬ ХК нь 100 хувь Монгол ноолуураар бүтээгдэхүүн үйлдвэрлэгч үндэсний ууган компани бөгөөд эдүгээ **44** дэх жилдээ үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна.

Бид олон зууныг дамжин уламжлагдан ирсэн ур ухааныг орчин үеийн үйлдвэрлэлийн дэвшилтэт технологитой хослуулан тав тухтай, удаан эдэлгээтэй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн хэрэглэгчдэдээ хүргэн ажиллаж байна.



КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА





ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ



Жилд нийт **2.5 сая ширхэг** бэлэн бүтээгдэхүүн

БРЭНДИЙН БҮТЭЦ






САНХҮҮГИЙН ҮР ДҮН


БОРЛУУЛАЛТ



БОРЛУУЛАЛТ, ЦЭВЭР АШИГ /тэрбум төгрөг/



БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, СЕГМЕНТЭЭР /тэрбум төгрөг, %/





ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	2024.06.30	2025.06.30		
		Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Өмнөх оноос өөрчлөлт	
				Тоо	Хувь
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	сая.төг	76,094	76,911	817	1%
Үүнээс: Дотоод борлуулалт	сая.төг	52,999	67,514	14,515	27%
Экспорт борлуулалт	сая.төг	16,822	3,903	(12,919)	-77%
Гадаад борлуулалт	сая.төг	6,273	5,494	(779)	-12%
Борлуулсан бүтээгдэхүүний тоо ширхэг	мян.ширхэг	308	283	(26)	-8%
БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ	сая.төг	42,300	41,409	(891)	-2%
НИЙТ АШИГ	сая.төг	33,794	35,503	1,709	5%
Нийт ашгийн хувь	хувь	44%	46%		2%
Үйл ажиллагааны зардал	сая.төг	31,934	36,175	4,241	13%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ	сая.төг	1,860	(672)	(2,532)	-136%
Үйл ажиллагааны ашгийн хувь	хувь	2%	-1%		-3%
Үйл ажиллагааны бус орлого (зардал)	сая.төг	(74)	(1,281)	(1,207)	-1631%
Санхүүжилтийн зардал	сая.төг	15,275	15,850	574	4%
Татварын өмнөх ашиг (алдагдал)	сая.төг	(13,489)	(17,802)	(4,313)	-32%
ЦЭВЭР АШИГ	сая.төг	(14,152)	(19,171)	(5,019)	-35%
Цэвэр ашгийн хувь	хувь	-19%	-25%		-6%
ҮЙЛДВЭРЛЭЛ	мян.ширхэг	531	488	(43)	-8%
Сүлжмэл бүтээгдэхүүн	мян.ширхэг	343	313	(30)	-9%
Нэхмэл бүтээгдэхүүн	мян.ширхэг	172	160	(12)	-7%
Оёмол бүтээгдэхүүн	мян.ширхэг	16	15	(1)	-6%
Үүнээс: Пальто	мян.ширхэг	8	10	2	20%
Пиджак	мян.ширхэг	3	1	(2)	-61%
Ээрмэл утас	тонн	112	93	(19)	-17%
АЖИЛТНУУДЫН ТОО	хүн	1,703	1,482	(221)	-13%
Нэг ажилтанд ногдох орлого	сая.төг	45	52	7	16%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	сая.төг	15,007	958	(14,049)	-94%
Нийт өр төлбөр	сая.төг	370,892	388,730	17,837	5%
Банкны зээл	сая.төг	324,071	311,133	(12,938)	-4%
Нийт хөрөнгө	сая.төг	360,337	356,477	(3,860)	-1%
Бараа материал	сая.төг	181,945	178,380	(3,565)	-2%
Маркетинг	сая.төг	3,847	3,174	(673)	-17%
Үүнээс: Гадаад маркетинг	сая.төг	2,502	2,334	(168)	-7%


САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ



Санхүүжүүлэгчийн нэр	Валют	Дуусах хугацаа	2024.06.30		2025.06.30	
			(мян.валют)	(мян.төг)	(мян.валют)	(мян.төг)
Банкны зээл						
Голомт банк (Урт хугацаат зээл)	MNT	2025	-	8,333,333	-	-
Голомт банк (Урт хугацаат зээл)	MNT	2027		-	-	17,700,000
Голомт банк (Зээлийн шугам)	MNT	2026	-	37,930,000	-	48,787,000
Голомт банк (Зээлийн шугам)	USD	2026	\$ 1,121	3,791,418	-	-
Голомт банк (Богино хугацаат зээл)	MNT	2025	-	9,500,000	-	-
Голомт банк (Богино хугацаат зээл)	MNT	2027	-	-	-	29,900,000
Хаан банк (Зээлийн шугам)	MNT	2025	-	5,600,000	-	-
Хаан банк (Зээлийн шугам)	USD	2025	\$ 5,013	16,949,204	-	-
Хаан банк (Богино хугацаат зээл)	MNT	2027	-	-	-	6,000,000
Хас банк (Зээлийн шугам)	MNT	2026	-	-	-	40,000,000
Хас банк (Зээлийн шугам)	USD	2026	\$ 11,840	40,031,632	-	-
Хас банк (Урт хугацаат зээл)	MNT	2027	-	-	-	12,000,000
Хас банк (Богино хугацаат зээл)	MNT	2025	-	10,000,000	-	-
Азийн хөгжлийн банк (ADB)	USD	2026	\$ 12,000	40,572,600	\$ 7,200	25,781,112
Азийн хөгжлийн банк (ADB)	USD	2026	\$ 18,000	60,858,900	\$ 10,800	38,671,668
Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (IIB)	EUR	2027	€ 14,000	50,600,760	€ 14,000	58,732,240
Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (IIB)	EUR	2027	€ 8,000	28,914,720	€ 8,000	33,561,280
Нийт /Банкны зээл/				313,082,567		311,133,300
Бондын санхүүжилт						
Бонд (Богино хугацаат зээл) *	USD	2025	\$ 3,250	10,988,413	-	-
Нийт санхүүжилт				324,070,980		311,133,300

Монгол банкны ханш /төг/

	2024.06.30	2025.06.30
USD	3,381.05	3,580.71
EUR	3,614.34	4,195.16



2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД БИД

2025 оны эхний хагас жилд:

- Үндсэн **1**, капсул **5** коллекц
- Шинэ нэр төрлийн **5** бүтээгдэхүүнийг хэрэглэгчиддээ танилцуулав.

2025 оны эхний хагас жилд хэрэглэгчдэд хүргэсэн коллекц, бүтээгдэхүүнүүд



ЦАГААН САРЫН
КАПСУЛ КОЛЛЕКЦ




CREATIVE VISIONS SS25
КОЛЛЕКЦ



CashmereTECH
ШИНЭ ЗАГВАР




Cashmere Insole
ШИНЭ НЭР ТӨРӨЛ



VALENTINE 2025
КАПСУЛ КОЛЛЕКЦ



Cashmere Denim Jacket
КАПСУЛ КОЛЛЕКЦ




Shawl
ШИНЭ ЗАГВАР



SILK 25
КАПСУЛ КОЛЛЕКЦ



3D NEW 25
КАПСУЛ КОЛЛЕКЦ



CASHMERE SHOES
BUCKLE STRAP BALLERINA
ШИНЭ ЗАГВАР



CASHMERE SHOES
WOMAN'S FLAT
ШИНЭ ЗАГВАР



БОРЛУУЛАЛТ
67.5
тэрбум төгрөг


52.9 ↑ 27%

2024.06.30

2025.06.30


2025 оны эхний хагас жилийн байдлаар дотоод зах зээл 67.5 тэрбум төгрөгийн борлуулалттай ажиллаж өмнөх оны мөн үеэс 27% өсөлтийг үзүүлэв.

БОРЛУУЛАЛТЫН БҮТЭЦ



Дотоод зах зээлийн борлуулалтыг бүтцээр нь авч үзвэл жуулчдын борлуулалт үнийн дүнгээр 30%-ийг эзэлж байна.

БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН /мян.шир/



↑ 355%

Борлуулсан бүтээгдэхүүний тоо ширхгийг нэр төрлөөр нь задалж харвал гутлын борлуулалт өмнөх оны мөн үеэс 355% өссөн байна.

ДОТООД ЗАХ ЗЭЭЛ



2025 оны эхний хагас жилд:



Чингис Хаан Олон Улсын Нисэх
Буудалд "ГОВЬ" брэндийн шинэ
салбар нээгдэв.

2025.03



Аялал жуулчлалын улирлын
нээлтийн арга хэмжээ болон
загварын шоу-го зохион байгуулж
хөтөч, жолооч, аяллын компаниудын
төлөөлөл бүхий нийт 251 зочинд
хамтран ажиллах төлөвлөгөөгөө
танилцуулж мэдээлэл хүргэв.


2025.03




"Ази-Номхон далайн бүсийн чуулган
Монгол Тэмүүлэл" НУТББ-тай
хамтран ажиллах гэрээ байгуулж, тус
арга хэмжээнд Платинум спонсроор
ивээн тэтгэн 5,000 гишүүдэд ГОВЬ-
ийг танилцуулан, JCI -тай хамтарсан
маркетинг хийв.

2025.06


ГАДААД ЗАХ ЗЭЭЛ



ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН БОРЛУУЛАЛТЫН БҮТЭЦ



2025 оны эхний хагас жилд нийт гадаад зах зээлд 9.4 тэрбум төгрөгийн борлуулалттай ажилласан. Үүнээс 42%-ийг экспортын борлуулалт, 58%-ийг гадаад борлуулалт эзэлж байна.



Говь брэнд АНУ-ын томоохон маркетинг компанийн нэг **MACY'S**-т 1-р улиралд нэгдсэн.

ВЕБСАЙТ

EU

- www.gobicashmere.com
- www.gobicashmere.com/DE
- www.gobicashmere.com/FR
- www.gobicashmere.com/PL

UK

- www.gobicashmere.com/UK

US

- www.gobicashmere.com/US

CN

- www.gobicashmere.CN

ПЛАТФОРМ

EU

- Zalando: DE, AU, FR, SW
- OTTO: DE

US

- Nordstrom
- Macy's

CN

- TMALL

САЛБАР ДЭЛГҮҮР

DE

- Berlin
- Düsseldorf



ХАМТЫН АЖИЛЛАГАА

GOBI × NP digital

Гадаад борлуулалтын зах зээлд 2023 оноос эхлэн SEO буюу Search Engine Optimization компаниудтай хамтран ажиллаж брэндийн органик хайлтыг сайжруулах дээр анхааран үе шаттай арга хэмжээг аван ажиллаж байна.

2025 оны эхний хагас жилд:

60,000+

Characters бүхий text
хэлбэрийн контент шинээр
оруулсан

25+

Онлайн уулзалт, хурлуудыг
зохион байгуулсан

50+

Task-ууд болон
сайжруулалтыг
вебсайтууд дээр
оруулсан

+29.1%

Органик хандалтын өсөлт

GOBI × M-Force

M-Force нь Японы маркетингийн шийдлээр мэргэшсэн байгууллага бөгөөд 2019 онд Казүки Нишигүчи тэргүүтэй мэргэжилтнүүдийн багийн санаачилгаар үүсгэн байгуулагдсан. Тус компани нь хэрэглэгчийн ойлголт, стратегийн төлөвлөлт, үр дүнгийн хэмжилт зэрэг чиглэлээр **"9 segs analyzer"** гэх үүлэн суурьтай хэрэгслийг санал болгодог бөгөөд энэ нь маркетингийн судалгааны салбарт шинэчлэл авчирсан байдаг.

2025 оны 02-р сараас эхлэн бид M-Force компанитай хамтран ажилласаар хэрэглэгчийн 9 сегментэд чиглэсэн стратегийн арга барилаа АНУ-ын зах зээлд хийхээр 2,000 гаруй хэрэглэгчдээс судалгаа авсан болно. Тус судалгааны үр дүнд харгалзан, хэрэглэгчдээ 9 сегментэд хуваарилж, сегмент тус бүрд зориулсан маркетингийн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөн ажиллаж байна.



ХАМТЫН АЖИЛЛАГАА

GOBI × Google Ads

Гадаад борлуулалтын зах зээлд 2020 оноос эхлэн Google Ads болон Meta Ads (Facebook, IG) компаниудтай хамтран ажиллаж брэндийн хайлтыг сайжруулах дээр анхааран үе шаттай арга хэмжээг аван ажиллаж байна.

2025 оны эхний хагас жилд:

23,900K+

Удаа сурталчилгааг хүмүүст
харуулсан

448K+

Удаа товшилтонд
хүргэсэн

20+

Онлайн уулзалтууд
зохион байгуулсан

+172%

CTR өсөлт

GOBI × salesforce

Salesforce нь дэлхийд тэргүүлэгч CRM системийн байгууллага бөгөөд 2022 оноос эхлэн хамтран ажиллаж байна. Salesforce нь имэйл маркетингийн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд харилцагчийн мэдээлэл хадгалах болон маркетингийн кампанит ажлыг зохион байгуулах боломжийг олгодог. Имэйл автоматжуулалт болон Newsletter-ын загварт сайжруулалт оруулсан.

2025 оны эхний хагас жилд:

5,000,000+

Имэйл харилцагч нарт
илгээсэн(давтагдсан тоогоор)

200+

Маркетингийн үйл ажиллагаа (имэйл)
явуулсан

+11.2%



2024 онтой харьцуулахад имэйлээр
орж ирсэн борлуулалтын өсөлт /US/

ПРОГРАММ ХӨГЖҮҮЛЭЛТ, ЦАХИМ ШИЛЖИЛТ



Компанийн хэмжээнд системийн шинэчлэлтийн ажлыг өргөжүүлэн INA-Manufacturing Execution System (MES) системийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг 2024 оны 07-р сараас эхлүүлсэн бөгөөд **2025 оны 1-р сараас эхлэн** үйл ажиллагаандаа төлөвлөгөөний дагуу амжилттай нэвтрүүлэн, ашиглаж эхлээд байна.

- Санхүүгийн удирдлага сайжруулалт
- Үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэх
- Эрсдэлийг удирдах
- Бодит дүн шинжилгээ
- Нэгдсэн процесс



- Бүтээгдэхүүний зах зээлд нэвтрэх хугацаа богиносох
- Бүтээгдэхүүний хөгжүүлэлт сайжрах
- Загварын түүхэн архив үүсэх

Үйлдвэр гүйцэтгэлийн систем (Manufacturing Execution System)


Үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмж нэмэгдүүлэх

Бүтээгдэхүүний чанар сайжруулах

Үйлдвэрлэлийн процессын сайжруулалт

Хяналтын үйл ажиллагаа нэмэгдэх

Ажилтнуудын ур чадвар нэмэгдэх



БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ (БОНЗ)





2024 оны **Байгаль орчин, нийгэм, засаглалын тайланг** бэлтгэн Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэв.



Азийн Хөгжлийн Банк (АХБ) -наас олгогдсон **Тогтвортой хөгжилтэй уялдсан зээлийн** (Sustainability-Linked Loan) гэрээний хүрээнд тодорхойлсон үндсэн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээ **(KPI)** олон улсын нэр хүндтэй, бие даасан аудит-баталгаажуулалтын байгууллага “DNV (Thailand) Co., Ltd.”-ээр амжилттай **баталгаажууллаа**.



Монгол улсын **эдийн засаг дахь ноолуурын салбарын оролцоо, нөлөөллийн** тухай судалгаа хийж буй Колумбын их сургуулийн судалгааны багтай хамтран ажиллав.




"Тогтвортой хөгжлийн стратегийн **бодлого**" болон түүнийг дагалдан гарсан Уур амьсгалын өөрчлөлт, Нийгмийн хариуцлага болон Хүний эрх, жендерийн бодлогуудыг **хэрэгжүүлэх дунд хугацааны буюу 2025-2029 оны төлөвлөгөөг батлав**.



Тос Холбооны бизнесийн гишүүн байгууллагуудын холбогдох салбаруудын стандарт, тайлагналыг хөгжүүлж, бэхжүүлэх зорилгоор үүсгэн байгуулсан **“ТоС Бизнес мэргэжлийн зөвлөл”**-д гишүүнээр элсэж, хамтран ажиллаж байна.



АХБ, Эдийн засгийн сэтгүүлчдийн клуб, Тогтвортой хөгжлийн төлөө сэтгүүлчдийн клуб хамтран зохион байгуулсан сэтгүүлчдэд зориулсан өдөрлөгт оролцож, Ноос ноолуурын салбарын болон Говь ХК-ийн тогтвортой хөгжлийн өнөөгийн байдал, энэ хүрээнд АХБ-тай **хамтран ажилласан туршлагаа хуваалцлаа**.



БАЙГАЛЬ ОРЧИН





ЯОУХАБ /JICA/-аас **Монголын эрчим хүчний нөхцөл байдалд үндэслэн, эрчим хүчний нийлүүлэлт болон нүүрс төрөгчийг бууруулсан зохистой тэнцвэр** буй болгоход чиглэсэн судалгаанд хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг төлөөлж оролцов.



JICA олон улсын байгууллага болон УСУГ-ын мэргэжилтнүүдэд шинээр барьж буй Говь ХК-ийн **Цэвэрлэх байгууламжийн** үйл ажиллагаа, технологийг танилцуулах арга хэмжээ зохион байгуулав.



“Говь” ХК-н эрчим хүч хэмнэх үйл ажиллагаанууд **“Эрчим Хүчний Тухай Хууль”**-ийн дагуу үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн 2024 оны ажлын дүнгээр **“Сайн”** үнэлгээгээр үнэлэгдэв.



Үйлдвэрийн хаягдал усны урьдчилан цэвэрлэх байгууламжийн төсөл нь 91 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Төслийн зураг төслийг Барилга хөгжлийн төв, холбогдох төрийн байгууллагуудаар хянуулж батлуулав.



ISO 14001 стандартыг хэрэгжүүлэх, компанийн үйл ажиллагаанаас үүдэх байгаль орчны нөлөөллийг бууруулж, эрсдэлийг хянах зорилгоор **“Байгаль орчны хяналт”**-ыг бүх үйлдвэр, газар нэгжүүдэд хийж гүйцэтгэлээ.


MNS 4943:2015

MNS 6734:2018

Цэвэрлэх байгууламжийн туршилт, тохируулгын ажлын явцад **MNS 4943:2015 “Хүрээлэн буй орчинд нийлүүлэх хаягдал усанд тавигдах шаардлага”, MNS 6734:2018 “Дахин ашиглах цэвэрлэсэн усанд тавигдах шаардлага”** стандартуудын шаардлагыг ханган ажиллаж байна.



Уур амьсгалийн өөрчлөлт, байгаль орчны яам, Нийслэлийн байгаль орчны газартай хамтран **ноос, ноолуур, арьс, шир боловсруулах үйлдвэрүүдэд** байгаль орчны менежмент, хуулийн хэрэгжилт, химийн бодисын менежмент зэргээг **сургалт болон туршлага судлах өдөрлөгийг зохион байгуулав.**



НИЙГЭМ



НИЙГЭМ



"Тогтвортой ноолуур гурван талт төсөл"-ийн хүрээнд 2025 оны ноолуурын дээжийг урьдчилан авч, ноолуур худалдан авах үйл ажиллагааг Баянхонгор аймгийн Жинст сум болон Хөвсгөл аймгийн Их-Уул суманд зохион байгууллаа. Уг үйл ажиллагааны хүрээнд нийт **5,075 кг ноолуур** худалдан авсан. Мөн тус хоёр аймгийн нийт **117 малчинд** бэлчээрийн менежментийн сургалт зохион байгуулсан.



Оролцогч талуудын хамтын ажиллагааны хүрээнд, оюуны бэрхшээлтэй иргэдийн спортын тэгш оролцоог дэмжих зорилгоор Special Olympics олон улсын тэмцээнд оролцох **Монгол Улсын баг тамирчдыг бүтээгдэхүүнээр ивээн тэтгэн, дэмжлэг үзүүлсэн.**

АХБ-ны техникийн туслалцаагаар хэрэгжиж буй **"Бэлчээрийн шийдэл"** төслийн хүрээнд Баянхонгор, Хөвсгөл аймгийн малчид, орон нутгийн иргэдтэй уулзалт хийж, төслийн зорилгоо талцуулан, бэлчээрийн зохистой менежментийн талаар малчдын саналыг сонсов.



ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ



LTI Давтамж - 0.0%

Ажлын байрны шалтгаант **хөдөлмөрийн чадвар алдалт үүсээгүй.**

1,548,000 хүн/цаг

Үйлдвэрлэлийн осол бүртгэгдээгүй буюу 1.5 сая хүн/цаг аюулгүй ажиллав.



Говь ХК-ийн Үйлдвэрчний эвлэл **Уламжлалт анагаах ухааны төв хүрээлэнтэй** хамтран эмчилгээ, сувилгаа шаардлагатай ажилтнуудаа эмийн бус эмчилгээнд хамруулан эрүүлжүүлэн чийрэгжүүлэх зорилгоор **60 ажилтнаа** Улаанбаатар рашаан сувилалд хэвтүүлэн сувилуулсан.



Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилтыг 3-р сарын 27-ны өдөр амжилттай зохион байгуулсан.



Үйлдвэрийн орчны хяналтыг Химийн бодисын хяналт, Өндөр эрсдэлтэй ажилбарын хяналт, өдөр тутмын хяналт, гал болон тоног төхөөрөмжийн **ажиллагааны хяналтыг** тогтмол тавьж ажиллаж байна.



3-р сард ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор **“Витаминжуулалтын аян”-ыг** зохион байгуулсан.




5-р сарын 6-ны өдөр Говь ХК-ийн **мэргэжлийн ангийн 10 ажилтан** Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, гал унтраах дадлага сургалтад хамрагдав.



Болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гал түймэр гарсан тохиолдолд авах арга хэмжээг бодит байдал дээр хэрэгжүүлэх, сургах зорилгоор сургалт зохион байгуулж давхардсан тоогоор **онолын сургалтад 66, практик сургалтад 41 ажилтныг хамруулав.**



“ХАБЭА-н нийт ажилтны сургалт”-ыг анх удаа ХЭМАБ-ын хэлтэс өөрсдийн дотоод нөөцөөр амжилттай зохион байгуулав. Сургалтад нийт 1,339 ажилтан, 10,712 хүн/цаг хамрагдаж, гүйцэтгэл 88%-тай байна.



Түүхий ноолууртай шууд харьцан ажиллах ажилтнуудыг хачигт энцефалитын халдвараас сэргийлэх зорилгоор 1,2-р тунд 22 ажилтан, 1-р тунд 33 ажилтан, 2-р тунд 23 ажилтан, 3-р тунд 5 ажилтныг хамруулав.

Нийт ажилтны тоо:



1,482



Эрэгтэй – **30%**
Нийт: **451**



Эмэгтэй - **70%**
Нийт: **1,031**


Байршлаар:



Монгол - 1,465 (99%)

- Улаанбаатар хот **1,462**
- Дархан **3**

Ажилласан жилээр:



- 20-оос дээш жил
- 10-20 жил
- 6-10 жил
- 2-6 жил
- 0-2 жил



Олон улс – 17 (1%)

- АНУ **1**
- Европ **16**

ХҮНИЙ НӨӨЦ



1 АЖИЛТАНД НОГДОХ
СУРГАЛТЫН ХҮН ЦАГ



0.65 хүн/цаг

НИЙТ СУРГАЛТЫН
ЗАРДЛЫН
ЗАРЦУУЛАЛТ



53.6 сая

СУРГАЛТЫН ТОО

80

СУРГАЛТАД
ХАМРАГДСАН
АЖИЛТНЫ ТОО

1,931
/Давхардсан
тоогоор/

Гадаад орны сургалт

- 1 удаагийн сургалт
- 2 ажилтан
- Зардал: 20.3 сая төгрөг

Гадны байгууллагын
сургалт


- 16 удаагийн сургалт
- 447 ажилтан
- Зардал – 17 сая төгрөг

Дотоод сургалт

- 63 удаа сургалт орсон
- 1,477 ажилтан хамрагдсан
- Зардал 0 төгрөг

Тэтгэлэгт хөтөлбөрийн
сургалт

- Бакалаврын зэргийн 4 жилийн сургалт
- 5 ажилтан хамрагдсан
- Зардал 16.3 сая төгрөг



ЗАСАГЛАЛ



ТОГТОЛЦООНЫ УДИРДЛАГА



Бид дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн Монгол ноолууран бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэдээ хүргэхийн тулд Монгол Улсын төдийгүй олон улсын стандартын шаардлагыг хангаж, удирдлагын тогтолцоогоо тасралтгүй сайжруулж байна.

OEKO-TEX® гэрчилгээ

УТАС



2021.07

ISO 14001:2015
гэрчилгээ



2022.08

MNS 6926:2021

“Текстилийн тогтвортой
үйлдвэрлэл”



2022.12

ISO 9001:2015
гэрчилгээ



2023.06

2021.06



“Органик бүтээгдэхүүн”
гэрчилгээ

2021.12



“Цэвэр ноолуур боловсруулах
зохистой дадал”-ын
Алтан батламжлал

2022.08



ISO 45001:2018
гэрчилгээ

2023.05



“Монголын Хаан Ширхэгт”
тохирлын гэрчилгээ

2024.02



OEKO-TEX® гэрчилгээ

БҮТЭЭГДЭХҮҮН



НЭГДСЭН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО




2-р сард Олон улсын **"OEKO-TEX STANDARD 100"** стандартын шаардлагыг хангаж бэлэн бүтээгдэхүүний гэрчилгээг амжилттай сунгав. Уг гэрчилгээний хамрах хүрээнд **сүлжмэл** бүтээгдэхүүнээс гадна **нэхмэл, оёмол** бүтээгдэхүүнийг оруулснаараа онцлог юм.



5-р сард **ISO9001:2015** стандартын магадлан аудитад амжилттай тэнцэв. Магадлан аудитын үр дүнгээр **1 үл тохирол болон 6 сайжруулах боломж** илэрсэн бөгөөд залруулах арга хэмжээний төлөвлөлт боловсруулан ажиллаж байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



НИЙТ ГАРГАСАН
ХУВЬЦААНЫ ТОО
780,112,500

НИЙТ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ТОО
25,416

2025.06.30-ны байдлаар

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

Хувьцаа эзэмшигчийн нэр	2024.12.31		2025.06.30	
	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь
Таван Богд Холдингс ХХК	681,267,736	87.33%	682,096,188	87.44%

Тайлант хугацаанд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт ороогүй бөгөөд хувь эзэмшил нь 0.11% нэмэгдсэн.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД



Ц.БААТАРСАЙХАН

ТУЗ-ийн дарга

Таван Богд Группийн
Ерөнхийлөгч



Б.АМАРСАЙХАН

-

Говь ХК-ийн Гүйцэтгэх
захирал



Д.ГЭРЭЛМАА

Нэр дэвшүүлэх хорооны дарга,
Эрсдэл, аудитын хорооны гишүүн

СЭЗИС, Бизнес удирдлагын
тэнхимийн профессор



А.ЖАРГАЛМАА

Эрсдэл, аудитын хорооны дарга
Цалин, урамшууллын хорооны
гишүүн

GAPE, ACCA ахлах багш,
хөтөлбөрийн удирдагч



Б.ОРГИЛ

Цалин, урамшууллын
хорооны гишүүн

Таван Богд Холдингс
ХХК-ийн Санхүү
удирдлага хариуцсан
захирал



Ц.ОРГИЛБОЛД

-

Говь Кашмер Европ ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



Д.ХУЛАН

Нэр дэвшүүлэх хорооны
гишүүн

Таван Богд Группийн ТУЗ-ийн
дарга



Д.ХҮРЭЛБААТАР

Цалин урамшууллын хорооны дарга,
Нэр дэвшүүлэх хорооны гишүүн



Б.ЦЭЭНЯМ

Эрсдэл, аудитын хорооны гишүүн

Таван Богд Холдингс ХХК-ийн
Дотоод аудит хариуцсан дэд захирал

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН БҮРЭЛДЭХҮҮНД ОРСОН ӨӨРЧЛӨЛТ

2025 оны Хувьцаа
эзэмшигчдийн ээлжит
хурлаар ТУЗ-ийн
бүрэлдэхүүнээ
шинэчлэн сонгон томилов.



Гүйцэтгэх захирал

Б.АМАРСАЙХАН



Дизайн,
үйлдвэрлэл
хариуцсан
дэд захирал

Б.БОЛОРМАА



Санхүү
хариуцсан
захирал

Б.ХАНГАЛАН



Гадаад
борлуулалт
хариуцсан
захирал

Г.АНУДАРЬ



Дотоод
борлуулалт
хариуцсан
захирал

Б.БИЛГҮҮНЖАВ



Мэдээлэл
технологи
хариуцсан
захирал

Б.ЭРДЭНЭ



Хүний нөөц
хариуцсан
захирал

Т.ИЧИНХОРЛОО



Бүртгэлийн
газрын
захирал

Д.СОДГЭРЭЛ



Дизайн
хөгжүүлэлтийн
газрын захирал

А.УЧРАЛ




Комплайнсын
газрын
захирал

Б.ЧИНГҮҮН



Говь ХК-ийн зах зээлийн үнэлгээ **2025.06.30**-ны өдрийн хаалтын ханшаар **192.7** тэрбум төгрөг байна.
Нэгж хувьцааны дундаж ханш **256.25** төгрөг (▲ 3.3%)

ҮЗҮҮЛЭЛТ	2025.03.31	2025.06.30	Өсөлт, бууралт
НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО /шир/	780,112,500	780,112,500	-
ХУВЬЦААНЫ ҮНЭ /төг/			
Хаалтын үнэ	239.00	247.00	3.3%
Хамгийн их үнэ	269.40	301.90	12.1%
Хамгийн бага үнэ	234.90	214.40	-8.7%
Дундаж үнэ	251.71	256.25	1.8%
АРИЛЖААЛАГДСАН ТОО /шир/			
Хамгийн их /өдөрт/	136,084	348,890	156.4%
Хамгийн бага /өдөрт/	1,167	945	-19.0%
Дундаж /өдөрт/	17,608	25,048	42.3%
Нийт	1,074,081	3,130,961	191.5%
АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН /төг/			
Хамгийн их /өдөрт/	33,759,555	102,325,019	203.1%
Хамгийн бага /өдөрт/	297,874	234,810	-21.2%
Дундаж /өдөрт/	4,431,836	6,514,547	47.0%
Нийт	270,341,986	814,318,425	201.2%
ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /төг/	186,446,887,500	192,687,787,500	3.3%



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ



№	Гарчиг	2024.12.31		2025.06.30	
		СЗХ-ны хяналтын оноо	Хэрэгжилт хувь	Өөрийн үнэлгээний оноо	Хэрэгжилт хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	100.0%	11	91.7%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	100.0%	9	90.0%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	100.0%	6	100.0%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	100.0%	6	100.0%
5	Эрсдэлийн удирдлага	8	100.0%	8	100.0%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	100.0%	6	100.0%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	100.0%	8	100.0%
8	Компанийн соёл	6	100.0%	6	100.0%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	9	90.0%	10	100.0%
Нэгдсэн дүн		71	98.6%	71	98.6%

Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээг 2024 оны эцсийн байдлаар Санхүүгийн Зохицуулах Хороогоор хянан баталгаажуулалт хийлгэхэд **98.6% буюу засаглал хэвийн, эрсдэлгүй гэж үнэлэгдсэн.** Харин 2025 оны эхний хагас жилийн байдлаар өөрийн үнэлгээг хийхэд 98.6% буюу өмнөх жилийн эцсээс өөрчлөлтгүй үр дүнтэй гарсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны хянан баталгаажуулалтын үр дүнг хүлээж байна.



ШҮГЭЛ ҮЛЭЭХ СИСТЕМ

2025 оны эхний улиралд шүгэл үлээх системээр нийт 39 мэдээлэл хүлээн авсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеийн 26 мэдээллээс **50%-аар** өссөн үзүүлэлттэй байна.

Эх сурвалж	Шүглийн тоо
Шүгэл үлээх системээр	27
Утсаар	7
Бусад сувгаар	5
НИЙТ	39

СУРГАЛТ

Хамрах хүрээ:

Албаны дарга болон
ахлах ажилтнууд




Сургалтын тоо: 1

Сургалтад хамрагдсан
ажилтнуудын тоо **34**

Гадны сургалт

Хамрах хүрээ:

Нийт ажилтан



Сургалтын тоо: 24

Сургалтад
хамрагдсан

Дотоодын сургалт
947

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

2025 оны 6-р сард Мэдээлэл технологийн аюулгүй байдлын нэвтрэх шалгалтын ажлыг мэргэжлийн түвшинд хийлгэж тайланг хүлээн авсан.

Ажлын зорилго:

Байгууллагын дотоод болон гадаад сүлжээ, веб систем, серверүүд, мобайл апп дээрх эмзэг сул байдлыг илрүүлэх, цаашид сайжруулах

Шалгалтын ажлаар илэрсэн эмзэг байдал:

Шалгалтын төрөл	Critical	High
Дотоод сүлжээ	35	25
Гадаад сүлжээ	11	18
Веб систем	1	9
Мобайл апп	-	4
НИЙТ	47	76

Авсан арга хэмжээ

Шалгалтын ажлын тайланд тусгагдсан шаардлагагүй хандалт, нээлттэй сүлжээний тохиргоог шинэчлэн аюулгүй байдлын арга хэмжээ авсан

Critical болон **High** түвшиний эмзэг байдлыг багасгах, арилгахаар төлөвлөгөө боловсруулан хийж гүйцэтгэнэ.



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

2025 оны эхний хагас жилд:

- “Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж батлуулав.
- Эрсдэлийн удирдлагын багийн гишүүдийг шинэчлэн томилж батлуулав.
- Шинэчлэгдэн батлагдсан журмын дагуу нийт газар, нэгжийн эрсдэл хариуцагч нэгжийн удирдлагуудтай уулзалт хийж эрсдэлийн үнэлгээ хийх маягт болон улирал бүрийн эрсдэлийн аппетитын гүйцэтгэл хэрхэн гаргах мэдээ мэдээлэл, заавар зөвлөмжийг өгөв.
- "Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх түвшний баримт бичиг"-ийг боловсруулж ТУЗ-ийн Эрсдэл аудитын хорооны гишүүдэд танилцуулав.
- 2025 оны хагас жилийн эрсдэлийн үнэлгээ болон аппетитын гүйцэтгэлийг нэгтгэн боловсруулж Эрсдэлийн удирдлагын баг болон Эрсдэл аудитын хороонд танилцуулав.

"Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх түвшний баримт бичиг"-ийг ТУЗ-ийн Эрсдэл аудитын хорооны гишүүдийн зөвлөмжийг тусган шинэчлэн боловсруулах, эрсдэлийн аппетитын гүйцэтгэл болон хариу арга хэмжээний төлөвлөлтийн биелэлтэд мониторинг хийх зэрэг ажлуудыг төлөвлөн ажиллаж байна.

Эрсдэлийн матрицын түвшин



Нөлөөлөл	Ихээхэн хэмжээгээр нөлөөлөх	3	4	0	0	0
	Их хэмжээгээр нөлөөлөх	5	6	3	1	0
	Дунд хэмжээгээр нөлөөлөх	16	14	28	8	5
	Бага хэмжээгээр нөлөөлөх	18	28	30	16	17
	Бараг нөлөөлдөггүй	57	39	16	2	8
		Маш ховор тохиолдох	Тохиолдох боломж бага	Заримдаа тохиолдох	Тохиолдох бүрэн боломжтой	Байнга тохиолддог
		Магадлал				

БИДНИЙ АМЖИЛТ, ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



4 жил тутам зохион байгуулагддаг өвлийн Тусгай Олимпод оролцох Монгол Улсын багаа дэмжин ноолууран бүтээгдэхүүнийхээ дээжээр гоёлоо.



Тогтвортой хөгжлийн зарчмуудыг хэрэгжүүлж хариуцлагатай үйлдвэрлэл эрхлэх зорилгоор “Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо”-нд гишүүнээр элслээ.



"ГОВЬ" брэндийн шинэ салбар Чингис Хаан ОУНБ-ын 2 дугаар давхарт, зорчигчдын хүлээлгийн танхимд нээгдлээ. Энэхүү салбар нь Монгол ноолуурыг олон улсад таниулах, мөн чанартай, дээд зэргийн бүтээгдэхүүнийг аялагчдад хүргэх шинэ боломжийг бий болгож байна.



Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2024 оны жилийн эцсийн байдлаар засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэхэд Говь ХК нь 98.6%-ийн үнэлгээ авч, нээлттэй хувьцаат компаниудаа дахин тэргүүллээ.



Аялал жуулчлалын улирлын нээлтийн арга хэмжээ болон загварын шоу-го зохион байгуулж хөтөч, жолооч, аяллын компаниудын төлөөлөл бүхий нийт 251 зочинд хамтран ажиллах төлөвлөгөөгөө танилцуулж мэдээлэл хүргэв.



Монгол Улсын Засгийн Газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим-с жил бүр уламжлал ёсоор Монголын ТОП 100 Аж ахуйн нэгжийг шалгаруулж Монголын үндэсний үйлдвэрлэгч Говь ХК дахин шалгарлаа.



GOBI

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа	2025 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2025 оны 06-р сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Компанийн нэр: “Говь” ХК УБГД: 9010001061 Үнэт цаасны код: MN00GOV03548 Албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот-17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК Утасны дугаар: (+976) 7013-9977 Факс: (976)-70143081 И-мэйл: info@gobicashmere.com Веб сайт: info.gobi.mn Фейсбүүк: GobiCashmere Онлайн дэлгүүр: Дотоод: gobi.mn Гадаад: gobicashmere.com
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Ямааны ноолуурт цогц боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	780,112,500
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн: М.Сэлэнгэ /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/ Хянасан: Б.Хангалан /Санхүү хариуцсан захирал/
1.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/

1.1.	Санхүүгийн байдлын үзүүлэлт		
	"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (мян.төг)		
		2024.12.31	2025.06.30
	ХӨРӨНГӨ		
	Эргэлтийн хөрөнгө		
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,326,046	2,264,713
	Дансны ба бусад авлага	3,512,304	8,339,984
	Урьдчилгаа төлбөр	9,404,878	7,109,487
	Бараа материал	122,708,175	178,380,448
		139,951,403	196,094,632
	Эргэлтийн бус хөрөнгө		
	Үндсэн хөрөнгө	153,147,719	146,820,860
	Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө	2,780,438	3,536,285
	Хойшлогдсон татварын хөрөнгө	5,661,214	4,322,697
	Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	4,736,726	5,702,545
		166,326,098	160,382,388
	Нийт хөрөнгийн дүн	306,277,501	356,477,020
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
	Богино хугацаат өр төлбөр		
	Дансны ба бусад өглөг	37,867,812	44,401,426
	Гэрээний өр төлбөр	2,129,778	2,833,777
	Богино хугацаат түрээсийн өглөг	1,103,295	1,471,387
	Орлогын албан татварын өглөг	381,026	362,398
	Богино хугацаат зээл	211,265,887	268,343,284
		252,747,798	317,412,272
	Урт хугацаат өр төлбөр		
	Урт хугацаат түрээсийн өглөг	1,922,734	1,844,215
	Урт хугацаат зээл	36,210,000	55,533,287
	Бусад урт хугацаат өглөг	-	-
	Хойшлогдсон татварын өглөг	13,939,844	13,939,844
		52,072,578	71,317,346
	Нийт өр төлбөрийн дүн	304,820,376	388,729,618
	Эзэмшигчдийн өмч		
	Хувьцаат капитал	780,113	780,113
	Дахин үнэлгээний нэмэгдэл	43,777,386	43,777,386
	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(12,119,789)	(26,658,051)
	Хуримтлагдсан алдагдал	(30,980,585)	(50,152,046)
		1,457,125	(32,252,598)
	Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	306,277,501	356,477,020

1.2.	Орлогын тайлан		
	"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН (МЯН.ТӨГ)		
		2024.12.31	2025.06.30
	Борлуулалтын орлого	247,026,317	76,911,486
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(138,552,341)	(41,408,677)
	Нийт ашиг	108,473,976	35,502,809
	Бусад орлого	3,649,691	1,516,809
	Борлуулалт ба маркетингийн зардал	(53,217,129)	(23,316,168)
	Ерөнхий ба удирдлагын зардал	(24,908,151)	(13,029,664)
	Бусад зардал	(6,919,419)	(2,635,969)
	Санхүүгийн орлого	4,465,583	9,566
	Санхүүгийн зардал	(33,118,100)	(15,849,545)
	Татварын өмнөх алдагдал	(1,573,549)	(17,802,164)
	Орлогын татварын өгөөж (зардал)	(2,083,660)	(1,369,298)
	Тайлант жилийн цэвэр алдагдал	(3,657,209)	(19,171,461)
	Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжтой бусад дэлгэрэнгүй орлого:		
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөлөөлөл	32,341,972	-
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний татварын нөлөөлөл	(8,085,493)	-
	Гадаад дахь охин компаниудын цэвэр хөрөнгийн гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүү	(1,457,515)	(14,538,262)
	Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй (алдагдал) орлого	22,798,964	(14,538,262)
	Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	19,141,755	(33,709,723)


1.3.	Өмчийн өөрчлөлтийн тайлан					
	"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН (мян.төг)					
		Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нөөц	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт
	2024 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	780,113	20,514,269	(10,662,273)	(28,316,738)	(17,684,629)
	Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(3,657,209)	(3,657,209)
	Бусад дэлгэрэнгүй орлого	-	24,256,479	(1,457,516)	-	22,798,963
	Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	-	24,256,479	(1,457,516)	(3,657,209)	19,141,754
	Хуримтлагдсан ашиг уруу шилжүүлсэн	-	(993,362)	-	993,362	-
	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	780,113	43,777,386	(12,119,789)	(30,980,585)	1,457,125
	Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(19,171,461)	(19,171,461)
	Бусад дэлгэрэнгүй алдагдал	-	-	(14,538,262)	-	(14,538,262)
	Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	-	-	(14,538,262)	(19,171,461)	(33,709,723)
	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
	2025 оны 06 сарын 30-ны үлдэгдэл	780,113	43,777,386	(26,658,050)	(50,152,046)	(32,252,598)
1.4.	Мөнгөн гүйлгээний тайлан					
	"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (мян.төг)					
				2024.12.31	2025.06.30	
	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ			29,728,027	(59,370,852)	
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ			(21,049,750)	(1,806,001)	
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ			(12,361,396)	58,884,714	
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ			(3,683,119)	(2,292,140)	
	Гадаад үйл ажиллагааг хөрвүүлсэн гадаад валютын ханшийн зөрүү			(1,457,516)	-	
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл			(24,430)	230,806	
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			9,491,111	4,326,046	
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			4,326,046	2,264,713	

3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт																				
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	<table><tr><th>Үзүүлэлт</th><th>2024.06.30</th><th>2025.06.30</th></tr><tr><td>Бохир ашгийн маржин</td><td>44%</td><td>46%</td></tr><tr><td>Цэвэр ашгийн маржин</td><td>-19%</td><td>-25%</td></tr><tr><td>Эргэлтийн харьцаа</td><td>0.7</td><td>0.6</td></tr><tr><td>Бараа материалын эргэц</td><td>510</td><td>478</td></tr><tr><td>Хувьцааны нэгж үнэ /₮/</td><td>262</td><td>247</td></tr></table>		Үзүүлэлт	2024.06.30	2025.06.30	Бохир ашгийн маржин	44%	46%	Цэвэр ашгийн маржин	-19%	-25%	Эргэлтийн харьцаа	0.7	0.6	Бараа материалын эргэц	510	478	Хувьцааны нэгж үнэ /₮/	262	247
Үзүүлэлт	2024.06.30	2025.06.30																			
Бохир ашгийн маржин	44%	46%																			
Цэвэр ашгийн маржин	-19%	-25%																			
Эргэлтийн харьцаа	0.7	0.6																			
Бараа материалын эргэц	510	478																			
Хувьцааны нэгж үнэ /₮/	262	247																			
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт																				
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	2025 оны эхний хагас жилд борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 1%-аар өссөн. Нийт борлуулалтын 88%-ийг дотоод, 12%-ийг гадаад зах зээл эзэлж байна. - Бүтээгдэхүүний загварын тоог бууруулж, өмнө нь худалдаанд гарч байсан, эрэлт ихтэй загваруудын масс үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэн. Ингэснээр хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн өнгө, размерын сонголт нэмэгдсэн. - Дотоодын зах зээлд бүтээгдэхүүний үнийн бодлогыг шинэчлэн, ижил төстэй загвартай бүтээгдэхүүн хоорондын үнийн ялгааг бууруулахад анхаарч ажилласнаар хэрэглэгчид сонголт хийхэд хялбар болсон. Мөн сошиал маркетингийг 2-р сараас илүү идэвхтэй болгосон нь дотоодын худалдан авалтыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн. 3-р сарын 1-нд Чингис Хаан Олон Улсын Нисэх Буудалд салбар дэлгүүрээ нээсэн. - Гадаад зах зээлд борлуулалтын сувгаа өргөжүүлж 1-р сараас АНУ-ын Macy's онлайн худалдааны платформоор бүтээгдэхүүнээ борлуулж эхэлсэн. - Дизайн хөгжүүлэлтийн хувьд CashmereTECH технологийн куртка, гутал болон бусад outsourcing бүтээгдэхүүний загвар технологийн сайжруулалт дээр анхаарч ажилласан. - Үйлдвэрлэлийн бүтээмжээ сайжруулах, өртгийг бууруулах хүрээнд 3D бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 2 дахин нэмэгдүүлснээр илүү бага хөдөлмөрөөр чанартай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг болсон. Мөн технологийн шинэчлэл хийж MES /Manufacturing Execution System/ болон дамжлагын системийг нэвтрүүлснээр үйлдвэрлэлийн удирдлага сайжирсан. - Говь ХК нь тогтвортой хөгжлийн зарчмуудыг хэрэгжүүлж, хариуцлагатай үйлдвэрлэл эрхлэх																			

		зорилгоор “Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо”-нд гишүүнээр элссэн. Мөн “Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого”-оо батлан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн Монгол ноолууран бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэдээ хүргэхийн тулд Монгол Улсын төдийгүй олон улсын стандартын шаардлагыг хангаж, удирдлагын тогтолцоогоо тасралтгүй сайжруулж байна.
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн байдлын гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгээгүй. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ Говь ХК-ийн “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ын дагуу жил бүрийн эхэнд Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах хэлцэл хийхийг зөвшөөрсөн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн жагсаалт болон хэлцлийн төсвийг ТУЗ-ийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар баталдаг. Дээрх журмын дагуу батлагдсан жагсаалтад ороогүй этгээдтэй хийх болон батлагдсан төсвөөс хэтэрсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийх бүрд тухайлсан тогтоолоор ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн зөвшөөрөл олгодог. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо нь Компанийн хэмжээнд хийгдэж буй сонирхлын зөрчилтэй хэлцэл нь батлагдсан төсвийн хүрээнд, зах зээлийн үнэ нөхцөлөөр, хуулийн дагуу хийгдэж байгаа эсэх дээр улирал бүрийн хорооны хурлаараа дамжуулан тогтмол хяналт тавьж ажилладаг. 2025 оны хувьд ТУЗ-ийн 2025 оны 03-р сарын 20-ны №07 тоот тогтоолоор тус зөвшөөрлийг олгосон. 2025 оны эхний хагас жилийн сонирхлын зөрчилтэй хэлцлийн гүйцэтгэлтэй 2025 оны 07-р сарын 07-ны Эрсдэл, аудитын хорооны ээлжит хурал дээр танилцан хяналт тавьсан.	

2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЛИЙН МЭДЭЭЛЭЛ							
Огноо	Гэрээ хэлцлийн утга	Үнийн дүн	Гэрээний нөгөө тал	Гэрээний нөхцөл, болзол	Эхлэх огноо	Дуусах огноо	Хэлцэл баталсан
2025.04.02	Хаан банкны зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	Зээлийн эрхийн хэмжээг 14 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх	Хаан Банк ХК	Таван Богд Холдингс ХХК болон түүний охин компаниудтай хамтарсан зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	2024.12.31	2027.12.31	ТУЗ-ийн тогтоол №13
2025.04.09	Хэвлэх үйлчилгээ авах	11.8 сая төгрөг	Улаанбаатар Принт ХХК	Хэвлэх үйлчилгээ авах	2025.03	2025.03	ТУЗ-ийн тогтоол №15
2025.05.14	Эргэлтийн хөрөнгийн ногоон зээлийн гэрээ байгуулах тухай	6 тэрбум төгрөг	Хаан Банк ХК	Ноос, ноолуур, арьс ширний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгийн ногоон зээл авах	2025.05.14	2027.05.14	ТУЗ-ийн тогтоол №21
2025.06.19	Андеррайтерийн үйлчилгээний гэрээ байгуулахыг зөвшөөрөх тухай	400 сая төгрөг	Таван Богд Капитал ҮЦК ХХК	Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх	2025.06.20	-	ТУЗ-ийн тогтоол №27
ХОЛБООТОЙ ТАЛУУДАЙ ХИЙСЭН ГҮЙЛГЭЭ (мян.төг)							
Холбоотой талуудтай хийсэн гүйлгээ					2024.06.30	2025.06.30	
Холбоотой талд өгсөн санхүүжилт					329,554,048	128,597,177	
Холбоотой талаас авсан санхүүжилт					345,297,000	162,927,177	
Холбоотой талтай хийсэн борлуулалт					81,044	570,250	
Холбоотой талаас авсан худалдан авалт					1,119,522	879,791	
Хүүгийн орлого					-	-	
Хүүгийн зардал					4,618,436	2,658,767	
Түрээсийн орлого					134,204	297,952	
Түрээсийн зардал					688,036	701,025	
<i>Жич: Холбоотой талууд гэдэгт Таван Богд Группийн охин компаниуд орсон болно. Эдгээр холбоотой талуудтай компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах зөвшөөрлийг ТУЗ-ийн 2025 оны 03-р сарын 20-ны №07 тоот тогтоолоор олгосон.</i>							
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл						
	Олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.						

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО

780,112,500

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО

25,416

/2025.06.30-ны байдлаар/

Таван Богд Холдингс ХХК

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

Хувьцаа эзэмшигчийн нэр	2024.12.31		2025.06.30	
	Хувьцааны тоо ширхэг	Хувь	Хувьцааны тоо ширхэг	Хувь
Таван Богд Холдингс ХХК	681,267,736	87.33%	682,096,188	87.44%

Тайлант хугацаанд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт ороогүй бөгөөд хувь эзэмшил нь 0.11% нэмэгдсэн.

2025 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04-р сарын 25-ны өдрийн 14:00 цагт ХААН театр (Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Сөүлийн гудамж-25, Хаан банкны Сөүл оффисын 1 давхар)-т амжилттай зохион байгуулагдав.

Хурлын ирц

Хуралд урьдчилан санал өгөх арга хэлбэрээр нийт 13,341,856 ширхэг хувьцааны 1.71 хувийн саналын эрхтэй 563 хувьцаа эзэмшигч, хурлын өдөр биечлэн оролцох арга хэлбэрээр 681,455,412 ширхэг хувьцааны 87.35 хувийн саналын эрхтэй 99 хувьцаа эзэмшигч буюу нийт 694,797,268 ширхэг хувьцааны саналын эрхтэй 662 хувьцаа эзэмшигч оролцсоноор хурлын ирц 89.06% болж бүрдэн хурал хүчин төгөлдөр явагдав.

Хурлаар танилцуулсан асуудал

1. Говь ХК-ийн 2024 оны санхүү үр дүн болон үйл ажиллагааны тайлан;
2. 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараахгүй тухай ТУЗ-ийн тогтоол;
3. ТУЗ-өөс компанийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар гаргасан дүгнэлт;
4. Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл;
5. ТУЗ-ийн 2024 оны ажлын тайлан, 2025 оны цалингийн төсөв;
6. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга.

ТУЗ-ИЙН ТОГТООЛ, ШИЙДВЭР

Тайлант хугацаанд ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод нийт 70 асуудлыг хэлэлцэн, 61 шийдвэр гаргаж, 35 тогтоолыг баталсан. Үүнд:

- ТУЗ-өөс 27 тогтоол (үйл ажиллагаа өргөжүүлэхтэй холбоотой 1, дотоод үйл ажиллагаатай холбоотой 13, санхүүжилттэй холбоотой 10, хүний нөөцтэй холбоотой 3)
- Эрсдэл, аудитын хорооноос 1 тогтоол,
- Нэр дэвшүүлэх хорооноос 6 тогтоол,
- Цалин, урамшууллын хорооноос 1 тогтоол.

Мөн чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 20 санал зөвлөмж, 20 үүрэг даалгавруудыг өгч, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллав. ТУЗ-ийн шийдвэр болон үүрэг даалгаврын биелэлт 100% хэрэгжилттэй байв.

НОГДОЛ АШИГ

Говь ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 02-р сарын 07-ны өдрийн [№02 тоот](#) тогтоолын дагуу компанийн 2024 оны санхүүгийн үр дүн нь компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийг хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ

Эхний хагас жилийн байдлаар дараах тайлан мэдээллийг хуулийн хугацаанд СЗХ болон МХБ рүү илгээн, олон нийтэд тайлагнан ажилласан.

- 2024 оны Жилийн үйл ажиллагааны тайлан (Монгол, Англи хэлээр);
- 2024 оны Аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт (Монгол, Англи хэлээр);
- 2024 оны Байгаль орчин, нийгэм, засаглалын үйл ажиллагааны тайлан;
- 2025 оны 1-р улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан;
- 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулсан тайлан материал;
- Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайлан (2024 оны жилийн эцэс болон 2025 оны хагас жилийн байдлаар);
- Тухай бүр хүргэх мэдээллүүд.

ШИНЭЭР БАТЛАГДСАН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

2025 оны эхний хагас жилд ТУЗ-өөс дараах бодлого, журмыг баталсан. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 1-р сарын Эрсдэл, аудитын хорооны хурлаар хэлэлцэн, ТУЗ-ийн 03-р сарын 20-ны [№08 тоот](#) тогтоолоор шинэчлэн баталсан.
- Дотоод аудитын дүрэм болон Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх түвшинг Эрсдэл, аудитын хорооны хагас жилийн хурлаар хэлэлцэн баталсан.

Засаглалтай холбоотой дэлгэрэнгүй тайлан мэдээлэлтэй Хавсралт дахь үйл ажиллагааны тайлангаас танилцана уу.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Хангалан

Албан тушаал: "Говь" ХК-ийн Санхүү хариуцсан захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)



Овог, нэр:

Албан тушаал: "..." Аудитын компанийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: М.Сэлэнгэ

Албан тушаал: "Говь" ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:

Огноо: 2025 оны 07-р сарын 25-ны өдөр